



Published in the Russian Federation
Bulletin of the Kalmyk Institute for Humanities
of the Russian Academy of Sciences
Has been issued since 2008
ISSN: 2075-7794; E-ISSN: 2410-7670
Vol. 30, Is. 2, pp. 63–69, 2017
DOI 10.22162/2075-7794-2017-30-2-63-69
Journal homepage: <http://kigiran.com/pubs/vestnik>

UDC 821.512.36

About the History of the First Edition of '*Mongolin Ubashi Hong Taijiin Tuuj*'

Mergen V. Boskhomdzhiev¹

¹ Postgraduate Student, College of Mongolian Studies, Inner Mongolia University (Hohhot, People's Republic of China). E-mail: oirat_mergen@mail.ru.

Abstract

In 1847, A.V. Popov published the *todo*-script text of '*Mongolin Ubashi Hong Taijiin Tuuj*' in Kazan (Russia). It is an important original manuscript of Oirat-Mongolian literature. The present paper discusses the origin, history of edition and content of the significant *todo*-script manuscript comprising three parts. First of all, it introduces conditions of research of '*Mongolin Ubashi Hong Taijiin Tuuj*' with evidence from the Russian, Mongolian, and Chinese texts and materials. As for its origin, the Russian researcher A.V. Popov mentioned in his *Kalmyk Language Grammar*: 'In 1838 I conducted field work in Kalmyk territories and published this book using the materials collected there'. Following his words, it is evident that A.B. Popov was the first person who had discovered the original manuscript of '*Mongolin Ubashi Hong Taijiin Tuuj*' and published it. The paper also gives an account of some problems related to its edition. Finally, the article provides a comparative study on the texts of '*Mongolin Ubashi Hong Taijiin Tuuj*' by A.B. Popov and G. Gomboiv dated back to different periods.

Keywords: A.V. Popov, '*Mongolin Ubashi Hong Taijiin Tuuj*', Oirat literature

«Монголын Увш хунтайжийн тууж» (цаашид өгүүлэхдээ тууж гэж дөхөмчилнө) бол Ойрадын аялга дээр суурилан тод монгол үсгээр бичигджээ. Тус тууж ОХ-ны Халимаг улст гар бичмэлээр болон амаар тархан уламжлагджээ. Харин Монгол улсын баруун хэсгийн Ойрад монголчуудын дунд зөвхөн гар бичмэлээр нэлээд арвин тархаж уламжлагджээ. Туужийн бар хэвлэлийн тухай гэвэл Оросын дотоод гадаадын эрдэмтдээс ОХ-ны Буриадын эрдэмтэн Галсан Гомбоев 1858 онд хэвлэсэн «Увш хун тайж жич түүний Ойрадтай дайралдсан түүх» (цаашид Галсан Гомбоевийн текст гэж дөхөмчилье) (История Убаши-хунтайджия и его войны с ойратами) [Гомбоев 1858: 213–224] хэмээх нэг гар бичмэл текстийг анхны эх мөртлөө анхны орчуулга хэмээн үзэж, түүний уран зохиол, хэл, түүх, гүн ухаан зэрэг талаас судлан шинжилсээр иржээ. Үүнд ОХ-ны Халимаг улсын эрдэмтэн А. В. Бадмаеваас «Галсан Гомбоевийн тууж»-ийг «орос хэлээр орчуулсан анхны орчуулагч» [Бадмаев 1967: 105] хэмээн үзжээ. Мөн Халимагийн эрдэмтэн В. П. Санчиров «туужийн Ойрад эхийг орос орчуулга тайлбарын хамтаар анх хэвлэгсэн буриад лам Галсан Гомбоев» [Санчиров 2007: 51] хэмээн үзсэн байдаг. Үүнээс гадна Монгол улсын эрдэмтэн Ц. Дамдинсүрэнгээс туужийг «Галсан Гомбиев (Гомбоев — М. Б.) 1858 онд тод үсгээр Санкт-Петербургт хэвлэж гаргасан байна» [Ринчиндорж 1987: 95] хэмээн дурьдсанаас эхлэн улсын дотоод олонх эрдэмтдээс Ц. Дамдинсүрэнгээс 1959 онд хэвлэсэн «Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой» хэмээх номд орсон туужийг судалгааны гол эх хэрэглэгдэхүүн болгон ашигласны зэрэгцээгээр туужийн анхны бар хэвлэлийн тухай эрдэмтэн Ц. Дамдинсүрэнгийн үзэлтийг баримтлан дагаж иржээ. Энэ тухай улсын дотоод дахь эрдэмтэн Мө. Өнө-Улаанаас «1858 онд буриад Монголын Гомбын Галсанг Санкт-Петербургт тус өгүүллэгийг анх тод үсгээр хэвлэсэн» [Өнө-Улаан 1983: 77]. Хэмээн үзсэн мөртлөө эрдэмтэн Цогвазандан [Цогвазандан 1980: 40], Будаа [Будаа 1983: 32], Сангиренчин [Сангиренчин 1984: 125], Сайшаалт [Сайшаалт 2011: 384], Мөнхөө [Мөнхөө 1984: 84], Дэлгэрсан [Дэлгэрсан 1989: 499], Нарс [Нарс 1999: 153], Бүринчин [Бүринчин 2004: 66], Мөлөн [Мөлөн 2007: 50] нараас Галсан Гомбоевийн текстийг туужийн анхны эх хэмээн дуу нэгтэй

баримталж иржээ. Гэхдээ миний гарт бий туужийн нэг олдвор бол буриадын эрдэмтэн Галсан Гомбоевийн 1858 онд хэвлэсэн эхээс 11 жилийн өмнө хэвлэгдсэн эх бичиг болно. Даруй 1847 онд Оросын эрдэмтэн Поповоос Оросын Казань хотод туужийг тод монгол үсгийн эхийн хамт орос хэлэнд орчуулж хэвлэсэн «Увш хунтайжын Ойрадыг дайлсан тууж»-ийн хэсэг (А. В. Поповын текст гэж дөхөмчилье) болох юм. А. В. Поповын текстийн эх бичигт холбогдох асуудлын талаар улсын гадаадад Халимагийн эрдэмтэн А. В. Бадмаев «Сарны гэрэл» номдоо нь «Хамгийн түрүү нь энэ дурсгалын нэг бяцхан тасархайг номд А. В. Попов тод үсгээр барлажээ. Орос хэлэнд тэр тасархайг орчуулсан өөрийнхөө дэвтэрт олзолсон юм» [Бадмаев 1991: 147–158] хэмээн товч дурьдсан боловч уг эхийг тод монгол үсгээр нийтэлсэн гэдгийг яриагүй мөртлөө энд тусгайлан судлаж шинжилсэн үгүй. Улсын гадаадад, дотоодод энэ тухай танилцуулга хийх буюу судалж шинжилсэн өгүүлэл одоо болтол харагдахгүйгээр, улмаар улсын дотоодийн олонх судлаачид энэхүү А. В. Поповын текстийн тухай хараахан мэдээ ч үгүй байсаар. Дор А. В. Поповын текстийг эх бичгийн хэвлэл, бар хэвлэл, текстийн агуулга гэж гурван талаас судлан шинжлэхийн зэрэгцээгээр туужид холбогдох зарим асуудлын тухай өөрийнхөө үзэлтээ дурьдахыг хичээв.

1. Эх бичгийн ирэл

1833 оны 7 сарын 20-ны өдөр Казанийн их сургуулийн монгол хэлний тэнхим байгуулагдсан юм. 1835 онд А. В. Попов профессор зэрэг хүртэж монгол хэлний багшаар ажилллажээ. Тэрбээр 1836 онд «Монгол хэл анхлан сурах бичиг» («Монгольская хрестоматия для начинающих»), 1837 онд «Монгол хэлний тоо бодлого» («Арифметика на монгольском языке»), 1847 онд «Халимаг хэлний зүй» («Грамматика калмыцкого языка») зэрэг бүтээлүүдийг хэвлэжээ. А. В. Поповоос «Халимаг хэлний зүй» хэмээх номондоо монгол хэлний зүйгийн жишээгээр туужийн нэг хэсгийг хэвлэжээ. А. В. Поповоос «Халимаг хэлний зүй» бүтээлээ 2 сар гаруй Халимагуудын дотор хийсэн хээрийн шинжилгээний хэ материалын суурин дээр туурвисан юм. Энэ тухай зохиолчоос «Миний бие 1838 онд Саратов болон Астрахан губерниар болоод Кавказын муж орон нутгаар оршин суугаа халимагуудын дунд хээрийн байцаалт хийж, тэндээс

цуглуулсан материалын суурин дээр тус бүтээлээ гаргасан гэсэн үг юм» [Попов 1847: 5]. Үүнээс үзвэл Додовын текст нь Халимаг тал нутгаас олдсон болох нь баттай юм. Юу ч гэсэн А. В. Поповын текст туужийн нэг хэсэг дутуу боловч, тэр нь Халимагаас олдсон эх гэдэг нь тодорхой мөртлөө, 1858 онд хэвлэсэн Г. Гомбоевийн текстээс 11 жилийн өмнө Казаньд хэвлэсэн нь баттай байна.

2. Бар хэвлэл

А. В. Поповын «Халимаг хэлний зүй» хэмээх ном бол хамгийн анхны Халимаг хэлний зүйгийн эрдэм шинжилгээний бүтээл болох юм. Тэр нь Казаны их сургуулийн хэвлэх хорооноос 1847 онд хэвлэгджээ. Тус ном нь өмнөх үг ('Предисловие'), нэгдүгээр хэсэг үгзүй ('Часть первая. Этимология'), хоёрдугаар хэсэг өгүүлбэрзүй ('Часть вторая. Синтаксис'), орчуулгын дадлага ('Упражнения в переводах') хэмээх гурван хэсгээс бүрджээ. Орчуулгын дадлага хэмээх хэсэгт нийт 9-нь тод монгол бичгийн сурвалжыг оруулжээ. Үүнд: Нэг: «Рашакын тууж оршвой» ('Сказание из сочинения Рашак ном'). Гурав: «Заябандидын намтрын тасархай» ('Рассказ из жизнеописания Зая-Пандиты'). Тав: «Увш хунтайжын Ойрадыг дайлсан туужийн хэсэг» ('Отрывок из сказания о походе Убаши-Хун-Тайчжия против Ойратов') гэх мэт.

А. В. Поповын текстийн үндсэн байдал гэвэл: уул тод тод монгол үсгийн текст «Халимаг хэлний зүй» хэмээх номын 366–369-р нүүрт бий. Текстийн гарчиг «Отрывок из сказания о походе Убаши-Хун-Тайчжия против Ойратов» («Увш хунтайжын Ойрадыг дайлсан туужийн хэсэг» — хэмээн нэрээр орчуулжээ) 366-р нүүрийн доод талд орос үсгээр тэмдэглэжээ. Текстийн эхэнд монгол судар бичгийн эртний уламжлалаар бярга тэмдэг «ᠶ» тавьжээ. Эцэст нь төгсгөлийн цэг «ᠰ» тавьсан байна. А. В. Поповын текст нь «*tegēd mongqoliyin turṣuul ercūsiyin māni qatalqār qatalād*» гэх хэсгээс эхлээд «...*oyiridiyin kübüin dörbön zögtü bi, mini zanggi ene gebe?*» гэх хэсгээр төгсдөг. Нүрний гарчгийг харвал нүүрт бүр арван дөрвөн мөртэй, тод монгол үсгийн текстийн дээд, доод орон зайг тэгш сайхан анхаарсан байна. 369–371-р нүүрт зарим Ойрад аялгууны үгийн утгыг орос хэлээр тайлбарлажээ. Жишээ нь: 1. *turṣuul* — войны, посылаемые для рекогносцировки (туршуур — хэл барих, илгээдэг цэрэг) 2. *māni* — название урочища, где существует

переправа через р. Иртыш недалеко от Зайсан-Нора (Маани — газрын нэр, энэ нь Зайсан нуурын орчимд буй Эрчис голын гатлаганы нэр болно) гэх мэт. Эдгээр 29-н үгээс 9-н үгт тайлбар хийлгүйгээр «3) § 42; 4) § 39; 8) § 22; 11) § 76; 13) § 17; 14) § 72; 15) § 5; 18) § 62; 20) § 36» гэх мэт тэмдэглэжээ. Бас зарим үгийн тайлбарт «7) *bi* вместо *buy*; *amitayin* вместо *amitani*» гэх мэт үгийн утгыг нь шууд оросоор тодорхойлсан бус, дэлгэрэнгүй тайлбар хийсэнгүй байна. Мөн «17) *arudani külētei* вместо *aru du inu külē tei* 'со связанными (руками) на спине его'. 19) *tegemēceqēn* вместо *teyimi ēce bēn* 'после того'. 25) *buluu* вместо *bile uu* 'есть ли или нет?' гэх мэт уг эх бичиг дахь үгсийн адил биш бичилгийг тодорхойлжээ. Утгыг нь оросоор орчуулсан юм. 371-р нүүрийн доод талд «*V. Перевод*» ('5. Орчуулга') гэж бичээд, 374-р нүүрийн дээд тал хүртэл уг текстийн орос хэлний орчуулгыг нь нийтэлжээ. Текстийн орос хэлний орчуулгыг нь ерөнхийдөө уг текстийн үг, үсгийн дагуу үсэгчлэн орчуулахын зэрэгцээгээр зарим ойлгомж муутай үгсийн ард нь хашилт тавьж тодорхойлолт, тайлбар хийсэн байна. Иймээс А. В. Поповын текст хэдийгээр эхэл ба төгсгөлийн текст дутуу боловч зохиолчоос «Халимаг хэлний зүй» хэмээх номоо нь туурвих явц дунд туужийн нэг хэсгийг оруулж хэлний зүйгийн талаас анхны ажиглалт хийжээ. Үгсийн тайлбар хадаад орос хэлээр орчуулж хэвлэсэн явдал нь туужийн эрдэм шинжилгээний бар хэвлэлийн түүхэнд дутагдаж болшгүй чухал эх хэрэглэгдэхүүн болох мөртлөө анхны судалгааны ирэл болсон байна.

3. Текстийн агуулга

Тус хэсэгт улсын гадаад, дотоодын эрдэмтдийн туужийн анхны текст хэмээн үзсээр ирсэн Г. Гомбоевийн текст, А. В. Поповын тексттэй харьцуулахаас дамжуулж, тэдгээрийн агуулгын ялгаа зөрөө мөн харьцаа холбооны тухай дөхөм өгүүлбэр. А. В. Поповын текст нь нийт 575-н үг болон 94-н цэг тэмдгээс бүрэлдсэн юм. Г. Гомбоевийн текстийг А. В. Поповын тексттэй харгалзуулсан хэсэг нь нийт 592 үг болон 84 цэг тэмдгээс бүрэлдэж байна. Ийнхүү Г. Гомбоевийн текст нь А. В. Поповын текстээс 21 үг илүү байхын зэрэгцээгээр 4 үг хасагдсан байна. Нэмэгдсэн үг гэвэл А. В. Поповын текстэд «*tegēd mongqoliyin turṣul*» гэж байхад, Г. Гомбоевийн текстэд «...*tegēd majigiin zakagsār mongqoliyin turṣoul*...»

гэж «*majigiyin zakagsār*» гэх үг нэмэгдсэн байна. А. В. Поповын текстэд «... *dolōn nasutai küböügi hatū ögetei zandan širē dēre ildü suqulād talbiba ...*», Г. Гомбоевийн текстэд «... *dolōn nasutai küböügi abqi irebai, küböügi hatū ügetei küböün geköügi sonosōd nayiman kültei zandan širē dēre ildü suqulād talbiba ...*» гэх мэт «*abqi irebai*», «*küböügi*», «*küböün geköügi sonosōd*» болон «*nayiman kültei*» үгс нэмэгджээ. Үүнээс гадна Г. Гомбоевийн текстэд «*ese*», «*ülii*», «*hoš örgē*» гэх 4-н үг хасагдсан бөгөөд байхгүй байна. А. В. Поповын текстийг Г. Гомбоевийн тексттэй харьцуулж үзвэл нийт хоёр үг солигдсон байна. Жишээ нь: А. В. Поповын текстэд «*уахаба қиги*» гэж гарахад Г. Гомбоевийн текстэд «*хайба қиги*» гэх, А. В. Поповын текстэд «*arban bars dūtai*», гэхэд Г. Гомбоевийн текстэд «*arban bars döütē*» гэх мэтээр солигдсон байна. Даруй Г. Гомбоевийн текст «*ягавч*» гэх үгийг «*хайвч*» гэж, «*дуутай*» гэх үгийг «*дүүтэй*» хэмээн эндүү бичсэн байв. Эдгээрээс үзэхэд А. В. Поповын текст хийгээд Г. Гомбоевийн текст нь ижил нэг эхээс ирэлттэй гэдэг нь тодорхой байна. Агуулгаас үзвэл санааны хувьд онцгой том зөрөөгүй боловч нарийн үг үсэг, өгүүлбэр, найруулгын хувьд бага сага зөрөөтэй байж харилцан нэг нэгэн нөгөөгөө нь нөхөлбөрлөх тал ч оршиж бий. Тод монгол үсгийн бичилгийн хувьд А. В. Поповын текст «*уйта*», «*қунан*», «*хотақайту хара хула*» гэхэд Г. Гомбоевийн текстэд «*уата*», «*қунун*», «*хотақайту хара халу*» гэх мэт нийт 107 үгийн бичлэг зурлага нь харилцан зөрөөтэй байна.

Дээрх мэт үгийн солигдол, нэмэгдэл, хасагдлыг гаргавал Г. Гомбоевийн текст нь А. В. Поповын тексттэй нийцэх агуулгын хэсэг нь их төлөв адил байна. Г. Гомбоевоос түүний ашигласан туужийн эх бичгийн тухай тодорхойлолт хийхдээ: «тус эх бичгийг хэвлэх үед бидний гарт гурван эх бичиг байсан юм. Үүнд бидэн тэдгээр эх бичгүдийн бичлэгийн зөрөөг харьцуулж буулгав. Уншлага, бичлэгийн зөрөө гэх хэсэгт нийт 51 үгийг харьцуулан буулгав. Бидний энд нийтэлж байгаа эх бичгийг А хэмээн тэмдэглэжээ.. бусад хоёр эх бичгийг В ба С эх бичиг хэмээн тэмдэглэв» [Гомбоев 1858: 211] гэжээ. Үүнээс үзэхэд Г. Гомбоевийн текст нь олон эхийг тулган харгуулж нэгдтгэсэн хэх байхад А. В. Поповын текстэд харин уг ямар нэгэн эх нь буулгавар байж мэднэ. Нөгөө талаар Г. Гомбоевийн текстийн агуулга үг хэллэг,

хүүрнэлийн дэс дараа мөн өгүүлбэрийн дэс дараа нь А. В. Поповын тексттэй ихээхэн ойролцоо байхаас харахад Галсан Гомбоевийн текстэд ашиглагдсан А, В, С гурван текстийн нэг нь А. В. Поповын текстийн ашигласан эх текст байж ер нь магадгүй.

Хураангуйлалт:

1. А. В. Поповын текст нь хэдийгээр туужийн нэг хэсэг дутуу боловч туужийн анхны бар хэвлэл гэдэг нь зайлшгүй байна. Тэр нь 170 гаруй жилийн турш эрдэмтдийн хараанд өртөөгүй он удсан нь харамсалтай.
2. Г. Гомбоевийн текст нь агуулга, үг хэллэг, хүүрнэлийн дэс дараа мөн өгүүлбэрийн дэс дараа нь Поповын тексттэй ихээхэн ойролцоо байхыг харахад Г. Гомбоевийн ашигласан А, В, С гурван текстийн нэгийг А. В. Поповын текстэд ашигласан нь магадгүй юм. Юу ч гэсэн А. В. Поповын текст нь Г. Гомбоевийн текстийг бодвол олон текстийг нийлүүлж найруулсан зүйл биш, харин уг эхийн нийтлэл гэдгээрээ онцгой ач холбогдолтой.
3. А. В. Поповын текстэд тод монгол үсгийн бичлэг нь туужийн бусад хувилбар лугаа ба ялгаа зөрөөтэй байх явдал нв туужийн хэл судлал, мөн уран зохиол, түүх зэрэг чиглэлд дутагдаж болшгүй ач холбогдолтой гэдэг нь яриангүй юм.

Тайлбар

1. «Монголын Увш хунтайжын тууж» нь бичгийн уламжлалын нэрийдлэгийн хувьд Германь улсын Дрезден хот дахь нэг сүм хийдийн архивд хадгалагдаж байгаа эх текстийн нэр нь «Дөрвөн Ойрад Монголыг дарсан тууж» хэмээх А. В. Поповын текст нь «Увш хунтайжын Ойрадыг дайлсан тууж» мөн Г. Гомбоевийн текст нь «Увш хунтайж жич түүний Ойрадтай дайтсан түүх» гэх мэт ялгаа зөрөөтэй тэмдэглэгдэж байхад аман уламжлалын нэрийдлийн хувьд ОХ-ны Халимаг улсад «Дөрвөн Ойрадын хөвүүн», «Монголын Увш хунтайж» гэх мэт бичиг ба аман уламжлалын нэрийдлэг нь адил бусаар уламжлагдаж иржээ. Тус өгүүлэлд улсын дотоод, гадаадын эрдэмтдийн хэрэглэж заншсан «Монголын Увш хунтайжын тууж» хэмээх нэрийдлийг хэрэглэв.

Литература

- Бадмаев А. В.* Две версии одного памятника ойратско-калмыцкой литературы // Вестник института. Вып. 2. Ч. 2. Серия филологии, философии, экономики и культуры. Элиста: КНИИЯЛИ, 1967. С. 105–112.
- Будаа Хү.* Монголын Увш хунтайжын туужын зохиогдсон цаг үеийн тухай дөхөм шинжилгээ (*Будаа Хү.* К исследованию времени создания истории монгольского Убаши хунтайджия) // Онгон сэрэл (Пробуждение онгонов), 1983. № 2. С. 30–51.
- Бүринчин Т.* Монголын Увш хунтайжын тууж дахь занги гэдэг үгийн тухай (*Бүринчин Т.* О слове «занги» в «Истории монгольского Убаши хунтайджи») // ӨМИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл (Научный журнал Университета Внутренней Монголии), 2004. № 5. С. 66–78.
- Гомбоев Г.* История Убаши хунтайджия и его войны с Ойратами». Перевод ламы Галсана Гомбоева // Труды Восточного отделения императорского археологического общества. СПб., 1858. Часть VI. С. 198–224.
- Дамдинсүрэн Ц.* Увш хунтайжын тууж («История Убаши хунтайджи») // Дамдинсүрэнгийн Ц. Уран зохиолын өгүүллүүд. Ренчиндорж нар шинэ үсгээс буулгав (Дамдинсүрэн Ц. Статьи по литературе. Переложение с кириллицы Ринчендоржа). Хөххот: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо (Хуххот: Издательство культуры Внутренней Монголии = Hohhot: Inner Mongolian Cultural Publishing House), 1987.
- Дэлгэрсан То.* Монголын Увш хунтайжын тууж (эрт, ойр үеийн монгол зохиогч хийгээд монгол зохиол) (*Дэлгэрсан То.* «История монгольского Убаши хунтайджи (монгольский автор раннего, позднего периода и монгольское сочинение)»). Хөххот: ӨМ-ын ардын хэвлэлийн хороо (Хуххот: Народный комитет по печати Внутренней Монголии), 1989. 501 с.
- Мөлөн.* Монголын Увш хунтайжын тууж дахь ахуйч ба хүсэхүйч аргын уялдал (*Мулун.* Согласование методов «хозяйствующего» и «желающего» в «Истории монгольского Убаши хунтайджи») // Дундад улсын Монгол судлал (Монголоведные исследования в Китае), 2007. № 6. С. 49–58.
- Мөнхөө Бу.* Монголын Увш хунтайжын тууж дахь гал гахайг шинжлэх нь (*Мунхуу Бу.* К изучению года «огня – свиньи», упоминаемого в «Истории монгольского Убаши хунтайджи») // Өвөр монголын нийгэм шинжлэх ухааны сэтгүүл (Общественно-научный журнал Внутренней Монголии), 1984. № 4. С. 81–97.
- Нарс Ба.* Дундад зууны Ойрадын өгүүллэгийн зохиол дахь түүх, уран зохиолын нэгдэл шинж (*Нарс Ба.* Общие наблюдения над историей и литературой в рассказах об ойратах средневековья) // Шинжааны Монгол утга зохиолын судлал (Исследования по монгольской литературе Синьцзяна). Хөххот: Үндэсний хэвлэлийн хороо (Хуххот: Национальный комитет по печати), 1999. С. 151–172.
- Өнө-Улаан Мө.* Ойрад монголын эртний гурван өгүүллэг (*Уну-Улан Му.* Три старинные истории об ойратах) // Алтан түлхүүр сэтгүүл (Журнал «Золотой ключ»), 1983. № 6. С. 75–91.
- Попов А. В.* Грамматика калмыцкого языка. Казань: Университетская типография, 1847. 392 с.
- Сайшаалт На.* Монголын уран зохиолын түүх (*Сайшаалт На.* История монгольской литературы). Хөххот: ӨМИС-ийн хэвлэлийн хороо (Хуххот: Комитет по печати Университета Внутренней Монголии), 2011.
- Сангиренчин Д.* Монголын Увш хунтайжын туужын тухай (*Сангиренчин Д.* Об истории монгольского Убаши хунтайджи) // ӨМИС-ын эрдэм шинжилгээний сэтгүүл (Научный журнал Университета Внутренней Монголии), 1984. № 3. С. 122–143.
- Санчиров В. П.* Монголын Увш хун тайжийн туужийн үйл явдлын он цагийг тогтоох асуудалд (К вопросу установления даты событий «Истории Убаши хунтайджи») // Bibliotheca Oiratica V. Халимаг: түүх, соёл (Калмыки: история, культура). Улаанбаатар: Соёмбо принтинг, 2007. С. 50–57.
- Цогвазандан.* Монголын Увш хунтайжын туужийн тухай дөхөм өгүүлэх нь (Еще раз об истории монгольского Убаши хунтайджи) // Шинжааны уран зохиол сэтгүүл (Литературный журнал Синьцзяна), 1980. № 6. С. 38–55.

References

- Badmaev A. V. *Dve versii odnogo pamyatnika ойратско-калмытской литературы* [Two versions of the same monument of Oirat-Kalmyk literature]. *Vestnik instituta* (Bulletin of the Institute), iss. 2, part 2, series 'Philology, Philosophy, Economics and Culture'. Elista, Kalmyk Research Institute of History, Language and Literature Press, 1967, pp. 105–112 (In Russ.).
- Budaa Khü. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzhyn zokhiogdson tsag üeiyn tukhay dõkhõm*

- shinzhilgee* [The time of creation of 'History of Mongolian Ubashi Hong Tayiji' revisited]. *Ongon serel* (Awakening of the Ongons), 1983, iss. 2, pp. 30-51 (In Mong.).
- Bürinčin T. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzh dakh' zangi gedeg ügiyn tukhay* [About the word 'zangi' in 'History of Mongolian Ubashi Hong Tayiji']. *ÖMIS-iyn erdem shinzhilgeeniy setgüül* (Scientific Journal of Inner Mongolia University), 2004, iss. 5, pp. 66-78 (In Mong.).
- Damdinsüren Ts. *Uvsh khuntayzhyn tuuzh* [History of Ubashi Hong Tayiji]. *Damdinsürengiyn Ts. Uran zokhiolyn ögüüllүүд. Renchindorzh nar shine üsgees buulgav* [Damdinsuren's articles on literature. Transliterated by Rinchendorj]. Hohhot, Inner Mongolia Cultural Publishing House, 1987 (In Mong.).
- Delgersan To. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzh (ert, oyr yeiyn mongol zokhiogch khiygeed mongol zokhiol)* ['History of Mongolian Ubashi Hong Tayiji' ...]. Hohhot, Inner Mongolia People's Printing Committee, 1989, 501 p. (In Mong.).
- Gomboev G. *Istoriya Ubashi khuntaydzhia i ego voyny s Oyratami». Perevod lamy Galsana Gomboeva* [History of Ubashi Hong Tayiji and his war against the Oirats. Transl. by Lama Galsan Gomboev]. *Trudy Vostochnogo otdeleniya imperatorskogo arkheologicheskogo obshchestva* (Transactions of the Oriental Department of the Imperial Archaeological Society). St. Petersburg, 1858, part VI, pp. 198-224 (In Russ.).
- Mölon. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzh dakh' akhuych ba khüsekhüych argyn uyaldal* [Artistic methods of 'History of Mongolian Ubashi Hong Tayiji']. *Dundad ulsyn Mongol sudlal* (Mongol Studies in China), 2007, iss. 6, pp. 49-58 (In Mong.).
- Mönkhöö Bu. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzh dakh' gal gakhayg shinzhlekh n'* [Revisiting the 'fire – pig' year mentioned in 'History of Mongolian Ubashi Hong Tayiji']. *Övör mongolyn niygem shinzhlekh ukhaany setgüül* (Inner Mongolia Journal of Social Sciences), 1984, iss. 4, pp. 81-97 (In Mong.).
- Nars Ba. *Dundad zuuny Oyradyn ögyyllegiyn zokhiol dakh' tüükh, uran zokhiolyn negdel shinzh* [General observations of the history and literature of the medieval Oirats]. *Shinzhany Mongol utga zokhiolyn sudlal* [Studies of Mongolian literature of Xinjiang]. Hohhot, National Printing Committee, 1999, pp. 151-172 (In Mong.).
- Popov A. V. *Grammatika kalmytskogo yazyka* [Kalmyk language grammar]. Kazan, Kazan University Press, 1847, 392 p. (In Russ.).
- Sanchirov V. P. *Mongolyn Uvsh khun tayzhiyn tuuzhiyn üyl yavdlyn on tsagiig togtookh asuudald* [The actual date of the event described in 'History of Ubashi Hong Tayiji' revisited]. *Bibliotheca Oiratica V. Khalimag: tüükh, soel* [Bibliotheca Oiratica V. The Kalmyks: history, culture]. Ulaanbaatar, Soembo Printing, 2007, pp. 50-57 (In Mong.).
- Sangirechin D. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzhyn tukhay* [About 'History of Mongolian Ubashi Hong Tayiji']. *ÖMBIS-yn (ili OMIS-yn) erdem shinzhilgeeniy setgüül* (Scientific Journal of Inner Mongolia University), 1984, iss. 3, pp. 122-143 (In Mong.).
- Sayshaalt Na. *Mongolyn uran zokhiolyn tüükh* [History of Mongolian literature]. Hohhot, Inner Mongolia University Press, 2011 (In Mong.).
- Tsogvazandan. *Mongolyn Uvsh khuntayzhyn tuuzhiyn tukhay dökköm ögüülekh n'* [One more time about 'History of Mongolian Ubashi Hong Tayiji']. *Shinzhany uran zokhiol setgüül* (Xinjiang Literary Journal), 1980, iss. 6, pp. 38-55 (In Mong.).
- Önö-Ulaan Mö. *Oyrad mongolyn ertniy gurban ögüülleg* [Three ancient stories about the Oirats]. *Altan tülkhüür setgüül* (The Golden Key journal), 1983, iss. 6, pp. 75-91 (In Mong.).

УДК 821.512.36

«МОНГОЛЫН УВШ ХУНТАЙЖЫН ТУУЖ»-ИЙН АНХНЫ БАР ХЭВЛЭЛИЙН АСУУДАЛД (ИЗ ИСТОРИИ ПЕРВОЙ ПУБЛИКАЦИИ «ИСТОРИИ МОНГОЛЬСКОГО УБАШИ ХУНТАЙДЖИЯ»)Мерген Владимирович Босхомджиев¹

¹ Аспирант, Институт монголоведения, Университет Внутренней Монголии (Хух-Хото, Китай).
E-mail: oirat_mergen@mail.ru.

Аннотация. В статье анализируется происхождение, публикация и содержание сказания «Истории монгольского Убаши хунтайджия», изданная в 1847 г. профессором А. В. Поповым на «ясном письме». Автор статьи на основе российских, монгольских и китайских материалов затрагивает некоторые вопросы, связанные с первой публикацией оригинального сказания. В вводной части рассматривается история публикации и исследования данного памятника ойратской литературы в России и за рубежом. В первой части статьи приводятся аргументы, подтверждающие ее калмыцкое происхождение. Так, например, профессор А. В. Попов, автор первой публикации сказания, указывал, что «... все рукописи на *тодо бичиг* и другие материалы, вошедшие в книгу «Грамматика калмыцкого языка», были собраны в 1838 г. во время научной экспедиции в калмыцкие степи». Во второй части описываются проблемы издания неполного сказания «История монгольского Убаши хунтайджия». В третьей части проводится сравнительно-сопоставительный анализ публикации А. В. Попова с полным текстом того же сказания, изданным ученым ламой Г. Гомбоевым.

Ключевые слова: А. В. Попов, «История монгольского Убаши хунтайджия», ойратская литература.